



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ухаалаг засаг-2 төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/050/НА-СТА-ТХН**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: [chantsaldulamp@audit.gov.mn](mailto:chantsaldulamp@audit.gov.mn)  
Аудитор: Т.Баасанцэнд  
Утас: 261628 Цахим хаяг: [baasantsendt@audit.gov.mn](mailto:baasantsendt@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг  
Утас: 99061771, 70001778 Цахим хаяг:  
[tungalag.s@imkaudit.mn](mailto:tungalag.s@imkaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.04 № 07/1387  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ухаалаг засаг-2 төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд 2024-2025 онд хэрэгжүүлэх нийт 55 дэд төсөл, арга хэмжээнээс, 47 дэд төслийн худалдан авалтыг зохион байгуулах ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичгийг боловсруулахаар төлөвлөж, нийт 21 ажлын даалгавар, техникийн шаардлага, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичгийг боловсруулан, сайжруулж ажилласан байна. Техникийн 6 тодорхойлолт, ажлын даалгаврыг шинээр боловсруулсны үр дүнд, Дэлхийн банкнаас санхүүжих 24 төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 51.0 хувийн санхүүжилтийн албан ёсны зөвшөөрлийг авсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ухаалаг засаг-2 төслийг 2023-2027 онд Дэлхийн банк, Олон Улсын Хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр нийт 40,700.0 мянган ам.доллаароор санхүүжүүлэхээр 7090-MN тоот гэрээг байгуулсан ба тайлант онд 405.7 мянган ам.долларын санхүүжилт олгогдож, санхүүжилтийн гүйцэтгэл 1.0 хувьтай байгаа нь төсөл нь хугацаандаа дуусахгүй байх эрсдэлтэй байна.

### **Бусад асуудал**

Ухаалаг засаг-2 төсөл нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	-	<b>12,709,089,369.02</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>12,709,089,369.02</b>
31200	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>12,709,089,369.02</b>
31210	<b>Төгрөг</b>	-	<b>58,870,256.79</b>
31211	Төрийн сангийн харилцах	-	58,870,256.79
31220	<b>Гадаад валют</b>	-	<b>12,650,219,112.23</b>
31221	Төрийн сангийн харилцах	-	12,650,219,112.23
32	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
32100	<b>Үнэт цаас</b>	-	-
33	<b>АВЛАГА</b>	-	-
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	-	-
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	-
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	-	-
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	-	<b>131,033,772.04</b>
37	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	-	<b>131,033,772.04</b>
39200	<b>Биет хөрөнгө</b>	-	<b>123,255,994.26</b>
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	-	93,430,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(5,150,555.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	35,569,372.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(592,822.88)
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	-	<b>7,777,777.78</b>
39301	Программ хангамж	-	8,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(222,222.22)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	-	<b>12,840,123,141.06</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	-	<b>12,840,123,141.06</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	-	<b>12,840,123,141.06</b>
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-	<b>12,840,123,141.06</b>
51220	Тайлант үеийн үр дүн	-	12,840,123,141.06
52	Хяналтын бус хувь оролцоо	-	-
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	-	<b>12,840,123,141.06</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>14,073,390,950.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>14,073,390,950.57</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>14,073,390,950.57</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>14,065,097,661.57</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	14,065,097,661.57
120009	Бусад орлого	-	8,293,289.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>1,240,032,357.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>1,112,751,586.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>1,112,751,586.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>396,226,264.52</b>
210101	Үндсэн цалин	-	396,226,264.52
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>49,529,128.39</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	34,392,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	4,060,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,275,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,681,928.39
210205	Эрүүл мэндийн даатгал	-	8,120,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>78,327,975.00</b>
210304	Байрны түрээс	-	78,327,975.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>6,310,772.34</b>
210401	Бичиг хэрэг	-	4,740,372.73
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,570,399.61
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>576,391,845.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	576,391,845.60
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>5,965,600.66</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	5,965,600.66
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>127,280,771.27</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>127,280,771.27</b>
222001	Хаагдсан данс	-	127,280,771.27
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	-	<b>12,833,358,592.79</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	<b>6,764,548.27</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	6,764,548.27
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	-	<b>12,840,123,141.06</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>14,073,390,950.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>14,073,390,950.57</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>14,073,390,950.57</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>14,065,097,661.57</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	14,065,097,661.57
120009	Бусад орлого	-	8,293,289.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1,106,785,985.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>1,106,785,985.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>1,106,785,985.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>396,226,264.52</b>
210101	Үндсэн цалин	-	396,226,264.52
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>49,529,128.39</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	34,392,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	4,060,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,275,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,681,928.39
210205	Эрүүл мэндийн даатгал	-	8,120,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>78,327,975.00</b>
210304	Байрны түрээс	-	78,327,975.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>6,310,772.34</b>
210401	Бичиг хэрэг	-	4,740,372.73
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,570,399.61
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>576,391,845.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	576,391,845.60
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	-	<b>12,966,604,964.72</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	<b>264,280,143.97</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>264,280,143.97</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>264,280,143.97</b>
222001	Тоног төхөөрөмж	-	127,280,771.27
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	136,999,372.70
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-	<b>(264,280,143.97)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-	<b>6,764,548.27</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	-	<b>6,764,548.27</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	6,764,548.27
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	-	<b>12,709,089,369.02</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,709,089,369.02

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	12,840,123,141.06	12,840,123,141.06
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>12,840,123,141.06</b>	<b>12,840,123,141.06</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,115,001,000.00</b>	<b>1,371,066,129.82</b>	<b>(743,934,870.18)</b>	64.8
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,135,001,000.00</b>	<b>1,106,785,985.85</b>	<b>(28,215,014.15)</b>	97.5
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,135,001,000.00</b>	<b>1,106,785,985.85</b>	<b>(28,215,014.15)</b>	97.5
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>406,000,000.00</b>	<b>396,226,264.52</b>	<b>(9,773,735.48)</b>	97.6
Үндсэн цалин	406,000,000.00	396,226,264.52	(9,773,735.48)	97.6
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,750,000.00</b>	<b>49,529,128.39</b>	<b>(1,220,871.61)</b>	97.6
Тэтгэврийн даатгал	34,510,000.00	34,392,200.00	(117,800.00)	99.7
Тэтгэмжийн даатгал	4,060,000.00	4,060,000.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	2,030,000.00	1,275,000.00	(755,000.00)	62.8
Ажилгүйдлийн даатгал	2,030,000.00	1,681,928.39	(348,071.61)	82.9
Эрүүл мэндийн даатгал	8,120,000.00	8,120,000.00	-	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>80,004,000.00</b>	<b>78,327,975.00</b>	<b>(1,676,025.00)</b>	97.9
Байрны түрээс	80,004,000.00	78,327,975.00	(1,676,025.00)	97.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,100,000.00</b>	<b>6,310,772.34</b>	<b>(3,789,227.66)</b>	62.5
Бичиг хэрэг	5,100,000.00	4,740,372.73	(359,627.27)	92.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,000,000.00	1,570,399.61	(3,429,600.39)	31.4
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,000,000.00</b>	-	<b>(10,000,000.00)</b>	-
Дотоод албан томилолт	10,000,000.00	-	(10,000,000.00)	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>578,147,000.00</b>	<b>576,391,845.60</b>	<b>(1,755,154.40)</b>	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	578,147,000.00	576,391,845.60	(1,755,154.40)	99.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>980,000,000.00</b>	<b>264,280,143.97</b>	<b>(715,719,856.03)</b>	27.0
Тоног төхөөрөмж	980,000,000.00	264,280,143.97	(715,719,856.03)	27.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,115,001,000.00</b>	<b>14,065,097,661.57</b>	<b>11,950,096,661.57</b>	665.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,115,001,000.00</b>	<b>14,065,097,661.57</b>	<b>11,950,096,661.57</b>	665.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,115,001,000.00	14,065,097,661.57	11,950,096,661.57	665.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,709,089,369.02	12,709,089,369.02	-

**3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**3.1 Аудитаар 1 зөрчил<sup>1</sup> илэрсэнд зөвлөмж өглөө.**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төслийн хариуцагч нэгж нь нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө Сангийн сайдын 100 дугаар тушаалаар баталсан маягт, аргачлалыг баримтлаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар 482,489.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Төслийн Удирдах хорооны 2024 оны 3 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Ухаалаг засаг-2 төслийн 2024 оны үйл ажиллагааны /гүйцэтгэлийн/ төлөвлөгөөгөөр нийт 26 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас 23 худалдан авалт зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
Нийт 14 хувь хүнтэй 482,489.7 мянган төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлыг худалдан авах цахим системээр хийгээгүй байна.	1	482,489.7	-	-	-	-	1	482,489.7
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>482,489.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>482,489.7</b>